



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/86/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Б.Үүрийнтуяа Утас: 89838414 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Т.НУРЛАН ТАНАА

2022.02.25 № 094
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо хийж хянан баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл няравын материалын тайлангаарх эхний үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөгөөр, жилийн эцсийн тооллогын дүнгээс 26.9 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дүн, тооллогын дүнгээс 42.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Эмийн 15.6 сая төгрөгийн үлдэгдэлийн тооллогын баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

2. Төрийн албан хаагчийн нэгдсэн цалингийн системээс гаргасан тайлант оны нийт 465.7 сая төгрөгийн цалингийн цэс нь алдаатай, дүнгүүд нь зөрүүтэй байгаагаас Мөнгөн

гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

3. Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн тайлангийн тодруулгыг заавар аргачлалын дагуу бэлтгэж ирүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.1, 14.3.2, 14.3.3, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалт, УСНББОУС-1 стандарттай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, толилуулга, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52,359,602.39</u>	<u>80,686,464.19</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	984,823.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	984,823.00
3121	Төгрөг	-	984,823.00
31211	Төрийн сангийн харилцах	-	984,823.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	2,390,632.00	18,197,937.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	74,632.00	1,278,698.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	16,919,239.00
335	Бусад авлага	2,316,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,316,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,968,970.39	61,503,704.19
351	Түүхий эд материал	11,318,514.34	15,618,848.14
35130	Эм боох материал	11,318,514.34	15,618,848.14
354	Хангамжийн материал	38,650,456.05	45,884,856.05
35410	Бичиг хэргийн материал	10,672,287.00	10,672,287.00
35420	Аж ахуйн материал	14,973,365.00	19,865,615.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,400,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	4,559,560.00	7,024,710.00
35460	Хүнсний материал	2,895,244.05	8,172,244.05
35470	Бусад хангамжийн материал	150,000.00	150,000.00
35500	Биологийн хөрөнгө	-	-
35600	Мал амьтад	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>831,392,547.06</u>	<u>823,978,545.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	831,392,547.06	823,978,545.58
392	Биет хөрөнгө	814,366,547.06	806,448,378.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	822,265,317.00	822,265,317.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(56,336,625.78)	(86,379,771.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,264,994.00	66,264,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,182,748.80)	(52,675,747.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,144,079.03	82,826,965.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,877,894.94)	(35,797,528.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,963,815.00	27,618,815.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,982,388.45)	(17,782,663.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	458,000.00	458,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(350,000.00)	(350,000.00)

39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	17,026,000.00	17,530,166.65
39301	Програм хангамж	-	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(45,833.35)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,026,000.00	17,026,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>883,752,149.45</u>	<u>904,665,009.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>753,273.46</u>	<u>783,860.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	753,273.46	783,860.00
413	Өглөг	753,273.46	783,860.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	753,273.46	783,860.00
41361	Байгууллагад төлөх өглөг	273,993.46	783,860.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	479,280.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>882,998,875.99</u>	<u>903,881,149.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	882,998,875.99	903,881,149.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	590,926,695.50	590,926,695.50
51101	Өмч: - төрийн	590,926,695.50	590,926,695.50
512	Хуримтлагдсан үр дүн	(259,652,910.48)	(238,770,636.70)
51210	Өмнөх үеийн үр дүн	(261,380,857.90)	(259,652,910.48)
51220	Тайлант үеийн үр дүн	1,727,947.42	20,882,273.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	551,725,090.97	551,725,090.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>883,752,149.45</u>	<u>904,665,009.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	622,057,750.00	822,502,703.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,171,701.00	23,687,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,171,701.00	23,687,600.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,171,701.00	23,687,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,501.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,166,200.00	23,687,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	614,886,049.00	798,815,103.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,772,280.00	630,126,736.02
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131005	Хөрөнгийн санхүүжилт	26,499,980.00	22,095,136.02
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	500,272,300.00	608,031,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,914,369.00	101,005,598.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	-

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,609,869.00	99,410,598.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,304,500.00	1,595,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,061,600.00	16,628,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,061,600.00	16,628,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,137,800.00	51,054,769.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,137,800.00	51,054,769.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	620,329,802.58	801,620,429.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	620,329,802.58	801,620,429.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620,329,712.58	756,820,429.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,472,573.00	481,523,606.00
210101	Үндсэн цалин	399,652,638.00	439,823,240.00
210102	Нэмэгдэл	602,350.00	35,071,145.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	6,217,585.00	6,629,221.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,853,993.00	70,156,685.00
210201	Тэтгэврийн даатгал	17,482,940.00	49,444,371.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,352,432.00	5,178,078.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,068,319.00	4,142,463.00
210204	Ажилгүйдлийн даатгал	813,664.00	1,035,615.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,136,638.00	10,356,158.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,358,969.00	14,718,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,614,969.00	1,914,731.00
210302	Түлш, халаалт	19,744,000.00	12,803,769.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,776,186.37	43,514,470.00
210401	Бичиг хэрэг	4,936,279.00	1,952,820.00
210402	Тээвэр, шатахуун	40,781,487.37	35,808,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,058,420.00	1,582,660.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,076,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,094,000.00
2105	Нормативт зардал	39,214,933.97	75,054,682.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,065,598.97	64,965,241.74
210502	Хоол, хүнс	10,657,335.00	10,059,441.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	492,000.00	30,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,474,091.00	18,824,632.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,402,500.00	18,458,001.00
210604	Урсгал засвар	2,071,591.00	366,631.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	1,660,000.00
210702	Дотоод албан томилолт	70,000.00	1,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	597,680.00	945,856.00

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	274,980.00	376,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	245,700.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	100,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	67,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	956.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,511,286.24	50,421,997.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,751,100.00	2,120,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,760,186.24	48,301,887.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90.00	44,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	44,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	44,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	90.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	90.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,727,947.42</u>	<u>20,882,273.78</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225003	Хөрөнгө оруулалтын гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,727,947.42</u>	<u>20,882,273.78</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(259,652,910.48)	882,998,875.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(259,652,910.48)	882,998,875.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(259,652,910.48)	882,998,875.99
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(259,652,910.48)	882,998,875.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(259,652,910.48)	882,998,875.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			20,882,273.78	20,882,273.78
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(238,770,636.70)	903,881,149.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	588,391,570.00	759,800,728.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,501.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,501.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,501.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,501.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	588,386,069.00	759,800,728.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,272,300.00	608,031,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	500,272,300.00	608,031,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,914,369.00	101,005,598.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,609,869.00	99,410,598.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,304,500.00	1,595,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,061,600.00	16,628,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,061,600.00	16,628,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,137,800.00	34,135,530.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,137,800.00	34,135,530.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	578,648,370.00	740,023,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578,648,370.00	740,023,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	578,648,280.00	695,223,155.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,263,678.00	496,223,628.00

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	263,727,800.00	317,185,920.00
210102	Нэмэгдэл	115,118,736.00	130,516,409.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		7,322,167.00
210104	Урамшуулал	23,417,142.00	41,199,132.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,768,850.00	56,444,657.00
210201	Тэтгэврийн даатгал	39,678,050.00	40,380,490.29
210202	Тэтгэмжийн даатгал	4,022,700.00	3,960,505.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,218,200.00	3,168,405.27
210204	Ажилгүйдлийн даатгал	804,500.00	785,707.62
210205	Эрүүл мэндийн даатгал	8,045,400.00	8,149,548.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,417,010.00	15,518,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,337,010.00	1,914,731.00
210302	Түлш, халаалт	20,080,000.00	13,603,769.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,729,696.00	41,896,163.00
210401	Бичиг хэрэг	1,911,186.00	3,534,703.00
210402	Тээвэр, шатахуун	29,735,090.00	35,676,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,083,420.00	1,949,260.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		735,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2105	Нормативт зардал	54,776,216.00	64,267,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,095,301.00	47,125,850.00
210502	Хоол, хүнс	9,512,915.00	14,830,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	168,000.00	2,312,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,139,350.00	14,567,130.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,494,850.00	13,457,630.00
210604	Урсгал засвар	1,644,500.00	1,109,500.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	2,590,000.00
210702	Дотоод албан томилолт	70,000.00	2,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	698,780.00	1,099,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	274,980.00	385,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	245,700.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		140,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	67,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	29,390.00
210807	Газрын төлбөр	101,100.00	101,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		77,387.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,784,700.00	2,615,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,784,700.00	2,615,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90.00	44,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	44,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		44,800,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	90.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	90.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,743,200.00</u>	<u>19,777,573.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,743,700.00	18,792,750.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,743,700.00	18,792,750.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,743,700.00	18,792,750.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,743,700.00	18,792,750.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,743,700.00)</u>	<u>(18,792,750.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(500.00)	984,823.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	500.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		984,823.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	664,950,600.00	657,810,447.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	664,950,600.00	657,810,447.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	664,950,600.00	657,810,447.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,158,500.00	456,508,633.00
210101	Үндсэн цалин	274,490,200.00	277,470,925.00
210102	Нэмэгдэл	134,430,800.00	130,516,409.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,064,000.00	7,322,167.00
210104	Урамшуулал	41,173,500.00	41,199,132.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,341,400.00	56,444,657.00
210201	Тэтгэврийн даатгал	42,335,100.00	40,380,490.29
210202	Тэтгэмжийн даатгал	4,581,600.00	3,960,505.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,665,300.00	3,168,405.27

210204	Ажилгүйдлийн даатгал	916,200.00	785,707.62
210205	Эрүүл мэндийн даатгал	8,843,200.00	8,149,548.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,518,500.00	15,518,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,337,100.00	2,337,100.00
210302	Түлш, халаалт	13,181,400.00	13,181,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,087,300.00	38,318,080.00
210401	Бичиг хэрэг	2,682,500.00	2,585,000.00
210402	Тээвэр, шатахуун	34,133,400.00	33,173,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,000.00	1,824,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	735,400.00	735,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2105	Нормативт зардал	54,387,800.00	53,713,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,423,800.00	37,749,600.00
210502	Хоол, хүнс	13,652,000.00	13,652,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,312,000.00	2,312,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,401,700.00	30,401,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,292,200.00	29,292,200.00
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	1,109,500.00	1,109,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,590,000.00	2,590,000.00
210702	Дотоод албан томилолт	2,590,000.00	2,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,250,100.00	1,099,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	385,000.00	385,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	140,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	67,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	29,390.00
210807	Газрын төлбөр	101,200.00	101,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	79,900.00	77,387.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,215,300.00	3,215,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,215,300.00	3,215,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	664,950,600.00	658,795,130.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	608,031,600.00	608,031,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	608,031,600.00	608,031,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,628,000.00	16,628,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	16,628,000.00	16,628,000.00

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,291,000.00	34,135,530.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	40,291,000.00	34,135,530.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		984,683.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	36
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	25	28
620003	Үйлчлэх ажилтан	6	7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	36
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	26	29
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,914,369.00	101,005,598.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,914,369.00	101,005,598.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,914,369.00	56,205,598.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	37,622,598.00
210101	Үндсэн цалин		37,622,598.00
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,462,450.00	-
210201	Тэтгэврийн даатгал	1,462,450.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,408,279.00	4,606,650.00
210401	Бичиг хэрэг	430,579.00	820,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,977,700.00	3,661,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		124,950.00
2105	Нормативт зардал	27,023,640.00	12,736,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,023,640.00	11,558,000.00
210502	Хоол, хүнс	2,000,000.00	1,178,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,020,000.00	1,240,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,020,000.00	1,240,350.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	44,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	44,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		44,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,914,369.00	101,005,598.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,914,369.00	101,005,598.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,609,869.00	99,410,598.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,304,500.00	1,595,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөрчил арилгуулах албан шаардлагын талаар тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь “Байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж, үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоход цахим сүлжээ өргөнөөр ашиглах, хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус төвд дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 618.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн гаргаж ирүүлсэн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.9 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		984.8	984.8
Авлага	2,390.6	18,197.9	15,807.3
Урьдчилгаа			-
Бараа материал	49,969.0	61,503.7	11,534.7
Үндсэн хөрөнгө	831,392.5	823,978.6	(7,413.9)
Нийт хөрөнгө	883,752.1	904,665.0	20,912.9
Өр төлбөр	753.3	783.9	30.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	882,998.8	903,881.1	20,882.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	883,752.1	904,665.0	20,912.9

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэнд үлдэгдэлгүй, оны эцэст 1.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Авлага дансны үлдэгдэл 18.2 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага, НДШ-ийн авлага гарсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 61.5 сая төгрөг болж 11.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 120.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 23.7 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 132.4 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 824.0 сая төгрөг болж 7.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэж, 22.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/09 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг

тооллого хийж тооллогын дүнг хэлэлцсэн боловч тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл няравын материалын тайлангаарх эхний үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөгөөр, жилийн эцсийн тооллогын дүнгээс 26.9 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дүн, тооллогын дүнгээс 42.0 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Эмийн 15.6 сая төгрөгийн үлдэгдэлийн тооллогын баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Өглөг дансны оны эхний 0.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст шинээр 0.8 сая төгрөг тээвэр шатахууны өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 903.9 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 20.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны анх батлагдсан төсөв 667.4 сая төгрөг ба тодотголоор 664.9 сая төгрөг болж 2.5 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 664.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 658.7 сая төгрөгийг зарцуулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 6.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу авч, 1.0 сая төгрөгийн зарцуулаагүй харилцахын үлдэгдэлтэй гарсантай холбоотой батлагдсан төсөв хэмнэлттэй гарсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс 608.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 16.6 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 34.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Нийт төсвийн 68.9 хувийг цалин, 9.1 хувийг НДШ-ийн зардал, 2.3 хувийг тогтмол зардал, 5.9 хувийг хангамж бараа материалын зардал, 8.2 хувийг норматив зардал, 4.6 хувийг эд хогшлын зардал, 0.4 хувийг томилолтын зардал, 0.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардлууд тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар 56.0 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн яамнаас хүлээн авч 13.6 сая төгрөгийг цалингийн зардалд, 1.7 сая төгрөгийг НДШ-д, 7.6 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 2.2 сая төгрөгийг норматив зардалд, 1.5 сая төгрөгийг томилолтын зардалд, 29.0 сая төгрөгийг тэтгэмжийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулж, тодруулаагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тул аудиторын дүгнэлтийг өөрчлөх үндэслэл болсон.

Сагсай сумын Эргэлтийн эмийн сангийн мөнгөн хөрөнгийн данс 5.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба арилжааны банкны 5188001219 тоот дансаар ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлтөөс 143.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 146.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 2.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Эмийн сангийн барилга 9.3 сая, тоног төхөөрөмж 16.7 сая нийт 26.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, эмийн зардалд 106.0 сая, эмийн санчийн цалинд 7.5 сая, нүүрсний үнэд 0.5 сая, урсгал засварт 5.3 сая, бусад зардалд 1.6 сая нийтдээ 146.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жилийн эцэст эмийн тайлангаар 9.8 сая төгрөгийн эмийн үлдэгдэлтэй гарчээ. Эргэлтийн эмийн сангийн тооцоо, санхүүгийн тайланг түүвэрт хамруулж шалгасан тул гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гарсан эсэхийг шалгах үзэх боломжгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 107 мэдээллийг байршуулж, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 89.9 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 1.9 сая төгрөгийн төлбөр барагдуулах акт, 86.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлснээс төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөрчил арилгуулах албан шаардлагыг 50 хувьтай биелүүлж, алдаа зөрчлийн давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлтэй данс, ажил гүйлгээнүүдэд түүвэр сорил хэрэгжүүлсэн тул төсвийн зарцуулалт, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Дараагийн аудитаар нягтлан болох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 793.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 197.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 595.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд дараах залруулга хийв. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнг 3.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Төсвийн гүйцэтгэлийг 93.9 сая төгрөгөөр зөрүүтэй гаргаж ирүүлсэн, 101.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн тайлан гаргаж ирүүлээгүй алдаа зөрчлийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 595.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/09 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллого хийж тооллогын дүнг хэлэлцсэн боловч тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл няравын материалын тайлангаарх эхний үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөгөөр, жилийн эцсийн тооллогын дүнгээс 26.9 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дүн, тооллогын

дүнгээс 42.0 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Эмийн 15.6 сая төгрөгийн үлдэгдэлийн тооллогын баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

2. Тайлант онд нийт 465.7 сая төгрөгийн цалин олгосон бөгөөд Төрийн албан хаагчийн нэгдсэн цалингийн системээс гаргасан цалингийн цэс нь алдаатай, дүнгүүд нь зөрүүтэй байгаагаас Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайланд цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэлийг тулган баталгаажуулах боломжгүй, ажилчдад олгосон 3.1 сая төгрөгийн урьдчилгааг суутгасан эсэх нь цалингийн цэсэд тусгагдаагүй, тодорхой бус байна.

3. Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн программыг бүрэн ашиглаагүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 4 хоног хоцроож 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлсэн. Санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн танилцуулгыг зааврын дагуу бэлтгэж ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ ...”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1 дэх хэсэг, “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-д “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана. 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар аргачлалын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын Эрүүл мэндийн төв	6	793.3	3	197.9			3	595.4		